

ГАН ХИЙЦ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улаанбаатар хот

2020.04.24

Ган хийц ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны ээлжит хурлыг 2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 11:40 минут компанийн ТУЗ-ийн даргын өрөөнд хийв.

Хуралд: Хувьцаа эзэмшигч М.Даваасүрэн, Би ди сек ҮЦК-ийн төлөөлөн О.Хонгорзул, Л.Чинбат, Лувсандорж нар оролцлоо.

Хуралд тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 90,96% буюу 220560 ширхэг хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирсэн тул Компанийн тухай хуулийн дагуу хурлын ирц бүрдсэн гэж үзээд хурлыг эхлэв.

Хурлын даргаар Хувьцаа эзэмшигч М.Даваасүрэн, нарийн бичгийн даргаар О.Ууганцэцэг нарыг сонгож батлав.

Хурлын дарга хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дотоод журмыг тус тус танилцуулж, батлуулав. Хурлыг 12:06 минут эхэлж, 13:00 цагт дуусахыг санал оруулж батлууллаа.

Бүх хэлэлцэх асуудлаа танилцуулж дуусаад санал хүсэлтээ хэлэх санал оруулж байна. /Хуралд оролцсон бүх гишүүд 100 хувь саналаар зөвшөөрөв./

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх
2. ТУЗ-ийн 2020 оны зардлын төсөв, Компанийн 2020 оны захиргаа, үйлчилгээний зардлын төсвийг батлах
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

Хэлэлцсэн нь: Хэлэлцэх асуудлыг бүгдийг танилцуулсны дараа санал асуулгадаа орох уу./100 хувь дэмжив/.

Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу **ТУЗ-ийн хийсэн ажлын тайлан болон компанийн үйл ажиллагааны талаарх** мэдээллийг ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн танилцуулав. Тайлан дараах чиглэлээр тайланг танилцуулав.

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан
 - ТУЗ, дэргэдэх хороодын талаарх мэдээлэл
 - ТУЗ-ийн 2019-2021 оны бүрэлдэхүүн
 - ТУЗ-ийн дэргэдэх хороодын хийсэн ажил
 - Ногдол ашгийн талаарх шийдвэр
 - Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл
2. Ган хийц ХК-ийн үйл ажиллагааны мэдээлэл
 - Танилцуулга
 - Удирдлагын бүтэц бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт
 - Ган хийц ХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Оюунзул
 - Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө түүний хэрэгжилт
 - 2019 оны улсад төлсөн татвар
 - ТУЗ-ийн болон ЗАА-н 2019 оны төсвийн гүйцэтгэл
 - 2019 оны бүтээн байгуулалтууд

2019 онд Ган хийц ХК-ийн Төмөр хийц үйлдвэрлэл, барилга угсралт 1,151 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой, захиалгат ажлуудын хийт төмөр хийцийн жин 340 тонн үйлдвэрлэсэн байна. 2019 онд 321,1 сая төгрөгийн татварын Улсын төсөвт төвлөрүүлсэн.

ТУЗ-ийн 2020 оны зардлын төсөв, компанийн үйл ажиллагааны 2020 оны зардлын төсвийн талаар танилцуулав.

Үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөг хавсралтаар танилцуулж байна. Үйлдвэрлэлтийг 450 тонн буюу 1,57 тэрбум төгрөг, барилга угсралтын ажил 315,0 сая төгрөг, бусад орлого 483,8 сая төгрөг, нийтдээ 2,4 тэрбум төгрөг төсөвлөсөн байна.

Захиргаа аж ахуйн болон үйлчилгээний зардал болон цалингийн санг Гүйцэтгэх захирлын оруулж ирснээр 600238660 төгрөгөөр та бүхэнд танилцуулж байна.

Бас нэг гол зардал бол Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал байдаг энэ зардлыг 134235600 төгрөгөөр санал оруулсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, нөхөн сонгох

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Д.Оюунзул нь Ган хийц ХК-ийн Гүйцэтгэх захирлаар 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн хурлаар томилогдсон тул Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх санал оруулж байна.

Д.Оюунзул захирлын оронд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр Булганы Гантулгыг томилох саналтай байна. Б.Гантулга нь 1983 оны 05 дугаар сарын 02-ны өдөр төрсөн.

2003 онд Г.В.Плехановын нэрэмжит ОХУ-ын эдийн засгийн академийг Эдийн засагч мэргэжлээр төгссөн. Ард лайф ХХК, Гүйцэтгэх захирал, ЛэндМН ХК, Гүйцэтгэх захирал, Сүү ХК, Гүйцэтгэх захирал, Анакс Аксис, Гүйцэтгэх захирал, Моннис Групп, Дэд захирал, Хас банк, Маркетингийн газрын захирлаар тус тус ажиллаж байсан туршлагатай залуу юм. Дэлгэрэнгүй анкетыг хавсаргасан тул танилцана уу.

М.Даваасүрэн: Анхаарал хандуулсан баярлалаа. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал дууслаа та бүхэн санал хүсэлтээ хэлнэ үү.

Би ди сек ҮЦК-ийн төлөөлөгч О.Хонгорзул: Хэлэлцсэн асуудал дээр нэмэх санал байхгүй. 2020 оны төсөв дээр нэмэх санал алга байна.

Лувсандорж: санал хүсэлт байхгүй тул дэмжиж байна.

Чинбат: Хэлэлцэж байгаа асуудлууд бүгд тодорхой, танилцуулагдсан тул татгалзах, асууж тодруулах зүйл байхгүй байна. Дэмжиж байна.

М.Даваасүрэн: Өөр асууж тодруулах зүйл байна уу. Байхгүй бол Тооллогын комисс байгуулж, ажилд нь оруулъя. Тооллогын комиссыг дараах хүмүүсийг сонгох саналтай байна.

Тооллогын комиссын даргаар Эко цаг ХХК-ийн нягтлан бодогч Т.Мөнгөнчимэг
Гишүүд Бичиг хэрэг архивын эрхлэгч Б.Нина
Нарийн бичиг О.Ууганцэцэг /100 хувийн саналаар батлав./

Тооллогын комисс бол таван асуудал дээр нэг санал хуудас хэвлэж санал хураалт явуулна.

Тооллогын комисс ажилдаа орж саналын хуудсыг тарааж өгнө үү. Ирсэн хувьцаа эзэмшигчид саналыг хуудсыг бөглөв./

Тооллогын комиссын дарга Т.Мөнгөнчимэг саналын дүн, тооллогын комиссын хурлын протокол, тогтоолыг уншиж танилцуулав. /протокол, тогтоолыг хавсаргав./

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон Б.Гантулгад Ажлын өндөр амжилт хүсч баяр хүргэе.

Даваасүрэн: Хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Цаашидын ажилд нь амжилт хүсье.

Шийдвэрлэсэн нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг ХАНГАЛТТАЙ гэж дүгнэв.
2. 2020 оны ТУЗ-ийн зардлын төсвийг 134 235 600 төгрөгөөр, Компанийн үйл ажиллагааны 2020 оны төсвийг 600 238 660 төгрөгөөр батлав.
3. Даваасүрэн овогтой Оюунзулыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс 2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлөв.
4. Булган овогтой Гантулгыг 2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрөөс эхлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилов.

Хурлын дарга М.Даваасүрэн хувьцаа эзэмшигчийн саналын дүнг үндэслэн шийдвэрлэсэн асуудалтай холбогдон гарах хурлын тогтоолын төслийг баталж, хурлаас гаргаж буй тогтоолыг уншиж танилцуулснаар хурал өндөрлөв. / тогтоолыг хавсаргав./

Хувьцаа эзэмшигчдийн хурал 2020 оны 04 дүгээр сарын 24 өдрийн 13:10 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн :

Нарийн бичгийн дарга



О.Ууганцэцэг

Танилцсан:

Хурлын дарга



М.Даваасүрэн